

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 08 дугаар сарын 20

Тендер шалгаруулалтын нэр: **“Чингэлтэй хайрхан уул орчмын тохижилтын 2 дугаар үе шатны ажил”**

/19-р хороо Дээд салхитын Эрдмийн цэцэрлэгт хүрээлэнд баригдах чулуун хийц бүхий тохижилт/

Тендер шалгаруулалтын дугаар: **ЧДХААА А18/050**

Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Чингэлтэй хайрхан уул орчмын тохижилтын 2 дугаар үе шатны ажил”**-ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө Чингэлтэй дүүрэг IV хороо Ж.Самбуугийн гудамж -16 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, Худалдан авах ажиллагааны албаны 511 тоот гэх хаягаар ирүүлнэ.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 100 000 /нэг зуун мянга/ төгрөгөөр худалдаж авна. Төлбөрийг Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны Төрийн сан банкин дахь 100200751009 тоот дансанд тушаана.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:Борлуулалтын орлогын дундаж хэмжээ: **Сүүлийн 2 жил /2016, 2017/-ийн дундаж нь 315 000 000 /гурван зуун арван таван сая/ төгрөгөөс багагүй байна.**

Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн ажлын туршлагын талаар мэдээлэл ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил /2016, 2017/-ийн аль нэг жилд ядаж нэг удаа 315 000 000 /гурван зуун арван таван сая/ төгрөгөөс багагүй үнийн дүнтэй чулуун хийц бүхий тохижилтын ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **135 000 000 /нэг зуун гучин таван сая/ төгрөгөөс багагүй байна.**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **/2016, 2017/ он.**

Шаардлагатай тусгай зөвшөөрөл:

Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог:

2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт

Эсхүл

Зам тээврийн сайдын 2013 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 152 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийг барих, засварлах тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам”-ын 3.7.1.1. ЗБ-1 Хатуу хучилттай зам барих заалтанд хамаарах төрлийн тусгай зөвшөөрөл

Тендерийн хамт 9 000 000 /есөн сая/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 10 цаг 30 минутанд нээнэ.

Гадаадын этгээд: Оролцох эрхгүй
Дотоодын давуу эрхийн зөрүү: Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, IV хороо, Ж.Самбуугийн гудамж-16, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, Худалдан авах ажиллагааны алба 511 тоот өрөө, Утас : 70110769